

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 08 сарын 21 өдөр

№ R-2025-36

Улаанбаатар хот

Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр батлах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11 болон 36.12 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.26 дахь хэсэгт тус тус заасны дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн R-2025-12 тоот тогтоолоор батлагдсан Банкны хувьцаа эргүүлэн худалдан авах өмнөх хөтөлбөр дуусгавар болсноос хойш үргэлжлүүлэн, 8 сарын хугацаатай хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг ТУЗ-д санал болгосныг; мөн
- ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын саналыг хэлэлцээд хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр (“Хөтөлбөр”)-ийг Банк өөрийн гаргасан энгийн хувьцааны 5,000,000 (таван сая) ширхэг хүртэлх хувьцааг эргүүлэн худалдан авах эрхтэйгээр, дараах нөхцөлөөр баталсугай:

1	Эргүүлэн худалдан авах хувьцааны тоо	5,000,000 ширхэг хүртэл
2	Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнэ	980 төгрөг хүртэл
3	Хөтөлбөрт зарцуулах нийт дүн	4,775,000,000 төгрөг хүртэл
4	Хөтөлбөр хэрэгжих хугацаа	8 сар

- Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа нь Монголбанкны зөвшөөрөл олгож, нийтэд зарласан өдөр эсхүл ТУЗ-ийн R-2025-12 тоот тогтоолоор батлагдсан хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр дуусгавар болсон өдрийн аль сүүлийн өдрөөс эхлэн 8 сарын хугацаанд үргэлжлэх ба нийт эргүүлэн худалдан авах хувьцааг бүхэлд нь худалдан авсан, эсхүл Хөтөлбөрт зарцуулах нийт дүнг бүрэн зарцуулснаар уг хугацаанаас өмнө дуусгавар болж болно.
- Хөтөлбөрийн дагуу эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасалсугай.

4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг энэ ажлыг зохион байгуулахтай холбоотой шаардлагатай, эсхүл зохистой гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
5. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



(Handwritten signature)

(Handwritten signature)

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ